АРХАНГАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2022 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны үйл ажиллагааны мэдээлэл

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус 9-р хуралдааныг 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр зохион байгуулж, тус хуралдаанаар Нутгийн удирдлагын төлөөллийн байгууллагын төлөөлөгч сонгох тухай, аймгийн Засаг даргад нэр дэвшүүлэх тухай асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэсэн.

Хурлын зөвлөл хуралдаж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит аравдугаар хуралдааныг 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр хуралдахаар товлон зарлаж, хуралдаанаар 14 асуудлыг хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн байна.

“Төлөөлөгчийн нэг өдөр” арга хэмжээний нэгдсэн дүнг 19 сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлэн, 10 сумын 17 төлөөлөгч хийсэн ажил, аймаг орон нутгийн талаарх бодлого шийдвэрийг тойргийн иргэдэд танилцуулах, төр, хувийн хэвшлийн байгууллагуудын санал бодлыг сонсох, тулгамдсан асуудалтай танилцах, холбогдох байгууллагуудад уламжлан тодорхой асуудлуудыг шийдвэрлэх арга хэмжээг зохион байгуулж, дээрхи сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагаатай танилцаж зөвлөмж хүргүүлсэн.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны мэдээлэл

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.1-д заасны дагуу Архангай аймгийн 2023 оны төсвийн төслийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн барьж, Х хуралдаанаар хэлэлцэн батлав.

2023 оны төсвийн төслийн онцлог нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, бусад хууль тогтоомжид өөрчлөлт орсонтой холбогдуулан, төр өөрийн зардлаа хэмнэх, оновчтой байдлаар дахин хуваарилах, төрийн үйлчилгээг цахимжуулах зэргээр бүх шатны төсвийн байгууллагууд хэмнэлтийн горимд ажиллах зарчмыг баримталж ажиллахаар боловсруулсан.

Архангай аймгийн төрийн захиргааны удирдах болон гүйцэтгэх 113 албан тушаалын 149 сул орон тоо, төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийн 8 албан тушаалын 8 сул орон тоо, нийт 121 албан тушаалын 157 сул орон тооны тусгай шалгалтын зар Төрийн албаны зөвлөлийн тусгай шалгалтын цахим системд зарлагдаж, тусгай шалгалтыг 2022 оны 12 дугаар сарын 13-20-ны өдрүүдэд зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна.

Засгийн газрын 2022 оны “Хөдөө аж ахуйн салбарын 2022-2023 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай” 277 дугаар тогтоол, Ерөнхий сайдын 2022 оны “2022-2023 оны өвөлжилт, хаваржилтийн болон ургац хураалтын бэлтгэл хангах тухай” 09 дүгээр албан даалгавар, аймгийн Засаг даргын 2022 оны “Өвөлжилтийн бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай” 04 дүгээр албан даалгаврын хүрээнд өвөлжилтийн бэлтгэл хангах ажлыг аймгийн хэмжээнд 91.3 хувьтай хангасан байна.

Боловсрол, шинжлэх ухааны яам, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн хамтран зохион байгуулж буй “Монголын боловсрол өнөөдөр” үндэсний нэгдсэн судалгааны хүрээнд Архангай аймгийн мэдээлэл цуглуулагч 144 иргэнд судалгааны мэдээлэл цуглуулах арга зүй, хүний нөөцийн чадавхжуулах сургалтыг 11 дүгээр сарын 21- 22-ны өдрүүдэд зохион байгуулж, “0-24 насны хүүхэд, залуучуудын боловсролын үйлчилгээнд хамрагдалт” үндэсний судалгаа Архангай аймагт 11 дүгээр сарын 18-ны өдрөөс эхэлсэн.

Аймгийн Засаг даргын тамгын газар НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн “Монголын унаган байгалийн хүлцэл, тогтворжилтыг хангах нь-ENSURE” төсөлтэй хамтран аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний агентлаг, төрийн өмчит аж ахуйн нэгж,

байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ, хүний нөөц хариуцсан албан хаагчдыг чадавхжуулах сургалтыг 2022 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр зохион байгууллаа.

Энэхүү сургалтад 69 төрийн албан хаагчийг хамруулж Төрийн албаны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт, төрийн албан хаагчийн ёс зүй, агентлаг, сумдын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам, хууль тогтомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах, бодлогын баримт бичгийн төлөвлөлт, тайлагналтад анхаарах асуудал багтсан.

Тариат суманд "Эрэн хайх, аврах бүлэг" байгуулагдаж, 11 дүгээр сарын 25-ны өдрөөс үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн бөгөөд Тариат сумын сум дундын Эрүүл мэндийн төвийн амбулаторийн зориулалтаар ашиглаж байсан барилгыг Эрэн хайх аврах бүлгийн мэдэлд шилжүүлж, Онцгой байдлын ерөнхий газар болон аймаг, орон нутгийн төсвийн нийт 140 сая төгрөгийн санхүүжилтээр тохижилтын ажлыг хийж гүйцэтгэсэн.

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Ensure төслийн хүрээнд Архангай аймгийн Батцэнгэл суманд сүүний үйлдвэр байгуулагдаж сумын иргэд үйлдвэрлэлийн аргаар сүүгээ боловсруулан ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг, цаашид аймгийн төв, Улаанбаатар хот руу бүтээгдэхүүнээ нийлүүлэх боломжтой боллоо.

2021 онд НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн газар, аймгийн ЗДТГ-ын хооронд байгуулсан харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд, Архангай аймгийг "Нүүдлийн соёл, аялал жуулчлалын олон улсын төв" болгон хөгжүүлэх судалгааны ажлын явцыг танилцуулах уулзалт хэлэлцүүлгийг 11 дүгээр 13-ны өдөр зохион байгуулж, Архангай аймгийг "Нүүдлийн соёл, аялал жуулчлалын олон улсын төв" болгон хөгжүүлэхэд шаардлагатай нөөц, зардал, үр ашиг, орчны хүчин зүйлийн нөлөөллийг тооцон, төслийн хэрэгжих боломжийг танилцууллаа.

2022 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр аймаг, сумдын удирдлагууд, үйлдвэрлэл эрхлэгчид, хөдөө аж ахуйн мэргэжилтэн, малчин иргэдийн төлөөлөл зэрэг 250 гаруй иргэн оролцсон "Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөний нээлтийн арга хэмжээг зохион байгуулж, аймгийн ИТХ-аар 2023 оныг "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг дэмжих жил" болгон баталлаа.

Аймгийн хэмжээнд жуулчны баазад 55, төрийн байгууллагад 75, аж ахуйн нэгжид 238, ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэгт 40, айл өрхөд 11728, нийт 12186 нүхэн жорлон, эко ариун цэвэрийн байгууламж (хөрсөнд нэвчихгүй соруулдаг болон төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон) жуулчны баазад 30, төрийн байгууллагад 48, аж ахуйн нэгжид 223, ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэгт 44, айл өрхөд 481, нийт 826 байна гэсэн дүн гарсан байна.

2022 оны 11 дүгээр сарын байдлаар Хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн сан LMIS программд ажил идэвхтэй хайгч 1078 иргэн бүртгэлтэй байгаагаас 495 эмэгтэй. Шинэ ажлын байр 658 үүнээс байнгын ажлын байр 361, улирлын ажлын байр 28, түр ажлын байр 269 байна.

Цахим шилжилт

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан "Цахим Архангай" төрийн шуурхай үйлчилгээг нэвтрүүлэх зорилтын хүрээнд Цахим хөгжил, харилцаа холбооны яамны зөвлөмжийн дагуу "Цахим аймаг" хөтөлбөрийн төслийг боловсруулж, хөтөлбөрийн зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчээр "Ай Си Ти групп" ХХК шалгарч, гүйцэтгэгчтэй 1.4 тэрбум төгрөгийн өртөгтэй гэрээ байгуулан хамтран ажиллаж байна.

"Цахим Архангай" хөтөлбөрийн хүрээнд аймгийн Нэгдсэн эмнэлэг, 19 сумын Эрүүл мэндийн төв, 33 ерөнхий боловсролын сургууль, 19 сумын Засаг даргын тамгын газар, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 28 агентлагт удирдлага, зохион байгуулалталтын цахим шийдэл, аймгийн нэгдсэн болон 19 сумын цахим хуудсыг шинэчлэх, хөрөнгө оруулалтын удирдлагын цахим шийдэл, аймгийн орон зайн мэдээллийн систем, автомат шалган нэвтрүүлэх цахим шийдэл, аймгийн иргэдэд зориулсан нэгдсэн гар утасны аппликейшн зэрэг системүүдийг үе шаттайгаар нэвтрүүлэх, системүүдийг ашиглалтад оруулахаар ажиллаж байна.

ХУР, ДАН системээр иргэдэд нийт 61 байгууллагын 660 төрлийн үйлчилгээг цахимаар үзүүлж, Архангай аймгийн нутгийн захиргааны 13 байгууллагын 51 үйлчилгээ шинээр "e-mongolia" системд нэмсэнээр орон нутгийн оператор ажилтнуудаар дамжуулан 211 үйлчилгээг цахимаар үзүүлж байна.

Сумдад төрийн цахим үйлчилгээг нэвтрүүлэх төслийн хүрээнд Архангай аймгийн Тариат, Өндөр-Улаан, Ихтамир сумдад 20 м өндөртэй харилцаа холбооны цамхаг угсарч суурилуулах, Цэнхэр, Хашаат сумдад үйлчилгээний нэгдсэн төвийн шинэ барилга баригдсан.

Мөн хөдөөгийн алслагдсан багуудыг холбоожуулах, 4G сүлжээний үйлчилгээ хүргэх төслийн хүрээнд Өндөр-Улаан сумын Азарга баг, Ихтамир сумын Бугат, Хөхнуур баг, Тариат сумын Алтаад багуудад холбогдох дэд бүтцийн ажлууд хийгдсэн байна.

Жаргалант сумын алслагдсан Зуслан багт Юнителийн 4G сүлжээний станц ашиглалтад орсон.

Хоёр. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд

Төсвийн орлого

2022 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн дүнгээр улсын төсвийн орлогод өссөн дүнгээр 2,460,931.9 мянган төгрөг төвлөрүүлэхээс 2,323,135.8 мянган төгрөг төвлөрүүлж, биелэлт 94,4 хувь, аймгийн төсвийн орлогод өссөн дүнгээр 1,926,855.9 мянган төгрөг төвлөрүүлэхээс 2,052,674.8 мянган төгрөг төвлөрүүлж, биелэлт 106.5 хувь, сумын төсвийн орлогод өссөн дүнгээр 12,930,084.1 мянган төгрөг төвлөрүүлэхээс 13,901,969.4 мянган төгрөг төвлөрүүлж, биелэлт 107.5 хувь байна.

Тендер, худалдан авах ажиллагаа

2022 онд улс, орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 123706.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 57 төсөл арга хэмжээний гүйцэтгэгч сонгон шалгаруулалтыг 100 хувь цахимаар зохион байгууллаа.

Үүнд: Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжих 116751.2 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 28, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих 5402.8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 19, Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын хөрөнгөөр хэрэгжих 396.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 4, Авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжих 1156.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 6 төсөл арга хэмжээ байна.

Төсвийн тодотголоор 700.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 2 төсөл арга хэмжээ цуцлагдсан.

2022 онд давхардсан тоогоор 88 удаагийн тендер шалгаруулалтыг зохион байгуулж, 122651.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 56 төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг шалгаруулж гэрээ байгуулсан, 355.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 1 төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 3 удаа зарлаж, гүйцэтгэгч шалгараагүй байна.

Хөрөнгө оруулалт

2022 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 81,527,8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 55 төсөл арга хэмжээ, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 3,704,9 сая төгрөгийн 24 төсөл, арга хэмжээ, орон нутгийн хөрөнгөөр хийгдэх их засвараар 1,100,0 сая төгрөгийн 11 төсөл арга хэмжээ тус тус хэрэгжихээр батлагдсанаас оны эхний 11 сарын байдлаар улсын төсвийн хөрөнгөөр 16,925,1 сая төгрөгийн, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 1,625,6 сая төгрөгийн, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх их засвараар 905,6 сая төгрөгийн санхүүжилт тус тус хийгдсэн.

Санхүүгийн хяналт

Сангийн сайдын баталсан нэгдсэн удирдамжаар цар тахлын улмаас Засгийн газраас айл өрх, албан байгууллага, аж ахуйн нэгжид цахилгаан, дулаан, хог, уур усны үнийн хөнгөлөлт үзүүлсэнтэй холбоотой хөнгөлөлт, чөлөөлөлт, үйлчилгээний

төлбөрийг нэхэмжилсэн тооцоог шалгах санхүүгийн хяналт шалгалт хийгдэж, улсын байцаагчийн актаар тогтоосон 149.8 сая төгрөгийн нөхөн төлбөрийг улсын төсөвт, 0.8 сая төгрөгийн төлбөрийг тухайн орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр шийдвэрлэж, 17.2 сая төгрөгийн зөрчил арилгуулахаар албан шаардлагаар хугацаатай үүрэг чиглэл өгч, аймгийн нэгдсэн дүн мэдээг Сангийн яаманд хүргүүлсэн.

2022 оны 11 дүгээр сард аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж байна.

Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд

Гамшиг осол

2022 оны 11 дүгээр сард гамшиг, аюулт үзэгдэл, ослын дуудлага нийт 9 удаа гарснаас: Объектын гал түймэр 4, газар хөдлөлт 1, мал, амьтны гоц халдварт мялзан өвчин 3, хүний гоц халдварт /ковид-19/ өвчин 1 тус тус гарсан байна.

Шүүхийн шинжилгээний алба 2022 оны 11 дүгээр сард шүүх эмнэлгийн шинжилгээ 49, криминалистикийн шинжилгээ 12, хэргийн газрын үзлэгээр илрүүлж бэхжүүлсэн ул мөр, эд мөрийн баримт 103, тусгай шинжилгээ 23-ыг тус тус хийсэн байна.

Архангай аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт 3135651.1 төгрөгийн мөнгөн дүн бүхий 563 гүйцэтгэх баримт бичиг ирснээс шийдвэр гүйцэтгэх бодит биелэлтийн хувь 53.2 мөнгөн дүнгийн дундаж үзүүлэлт 33 байна.

Улсын бүртгэлийн үйлчилгээ

2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар дараах бүртгэлийг тус тус хийж гүйцэтгэсэн байна.

Иргэний бүртгэл

Төрсний бүртгэл – 155
Овог эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр өөрчилсний бүртгэл - 3
Эцэг /эх/ тогтоосны бүртгэл - 2
Гэрлэсний бүртгэл - 30
Гэрлэлт дуусгавар болсны бүртгэл - 6
Үрчилсний бүртгэл - 2
Нас барсны бүртгэл – 45
Шинээр иргэний үнэмлэх олгосон – 108
Дахин олгосон – 42
Солиулсан - 169

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл

Газар өмчлөх эрхийн анхны бүртгэл – 13
Үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхийн анхны бүртгэл – 17
Шинээр бүртгүүлсэн орон сууцны бүртгэл - 19
Худалдах худалдан авах гэрээ – 46
Бэлэглэлийн гэрээ – 5
Барьцааны эрхийн бүртгэл – 193
Өв залгамжлал – 5
Лавлагаа – 4
Бусад эрхийн бүртгэл – 12

Хууль хяналтын байгууллагад нийт 49 лавлагааг гарган хүргүүлсэн. Дээрхи бүртгэлүүдийг хийж үйлчилгээний хөлс 2454126 төгрөг, тэмдэгтийн хураамжид 286882 төгрөг, үл хөдлөх хөрөнгө худалдсанаас оруулсан татварын орлого 9844000 төгрөгийг тус тус улсыг төсөвт төвлөрүүлсэн байна.

Хуулийн этгээдийн улсын бүртгэл

Шинээр бүртгүүлсэн – 11
Өөрчлөлт – 14

Тамганы хяналтын дугаар олгосон – 16

Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд

Боловсрол

Аймгийн хэмжээнд 2022-2023 оны хичээлийн жилд ерөнхий боловролын сургуульд 19600, хүүхдийн цэцэрлэгт 6700, нийт 26300 суралцагч боловсрол эзэмшиж байна.

Энэ хичээлийн жилд Архангай аймагт 2047 хүүхэд 1-р ангид элсэн орсон. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын салбарын 2022-2023 оны хичээлийн жилийн зорилгыг "Хүүхдийн нийгэм, сэтгэл зүй, танин мэдэхүйн хөгжлийг дэмжих, боловсрол эзэмшихэд тулгарч буй бэрхшээлийг арилгаж, сурах тэгш боломж бүрдүүлэх, хувь хүний онцлогт нийцүүлэн сургалт, үйл ажиллагааг чанар, үр дүнтэй зохион байгуулах, хамтран суралцах арга барилыг сургалтад нэвтрүүлэх" хэмээн тодорхойлж ажиллаж байгаа бөгөөд боловсролын байгууллагуудын үйл ажиллагаа хэвийн, жигд явагдаж байна.

2022 онд боловсролын салбарт улсын болон орон нутгийн төсвийн 41.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар нийт 26 барилга, өргөтгөл, их засварын ажил, үүнд багшийн хөгжил, судалгааны арга зүйн төв-1, сургууль-8, дотуур байр-1, цэцэрлэг-7 нийт 17 барилгыг улсын төсвийн 40,4 тэрбум төгрөгийн хөрөнгөөр шинээр барих, сургууль- 3, спорт заал-4, цэцэрлэг-1 нийт 8 барилгад улсын төсвийн 200,0 сая, орон нутгийн хөгжлийн сангийн 902,0 сая, нийт 1,1 тэрбум төгрөгийн их засварын ажлыг тус тус гүйцэтгэсэн байна.

Эрүүл мэнд

Хүн амыг зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэг шинжилгээнд Архангай аймгийн 0-5 насны 12595, 6-17 насны 21906, 18-30 насны 19416, 31-45 насны 19824, 46-60 насны 15103, 61-ээс дээш насны 7023, нийт 95867 иргэн хамрагдахаас 2022 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн байдлаар 0-5 насны 3855, 6-17 насны 6777, 18-30 насны 1346, 31-45 насны 1004, 46-60 насны 569, 61-ээс дээш насны 120, нийт 13671 иргэн хамрагдаж, хамрагдалт 14.2 хувьтай, эрүүл илэрсэн иргэн 6209, эрсдэлтэй илэрсэн иргэн 474, өвчтэй илэрсэн иргэн өвчтэй илэрсэн 7028 байна.

Эрдэнэмандал сумын Сум дундын Эрүүл мэндийн төвд Японы хүүхдийг Ивээх сангийн "Денан төсөл"-ийн санхүүжилтээр зөөврийн рентген аппаратыг суурилуулж ашиглаж байна.

Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын нөхцөл байдал

/2022.11.29-ны өдрийн байдлаар/

Батлагдсан тохиолдол:

Нийт батлагдсан тохиолдол /2021-2022 он/-18042

Үүнээс : 2022 онд - 5179

Сүүлийн 7 хоногт батлагдсан тохиолдол - 24 /11-р сарын 23-29/

Нас баралт:

Нийт нас баралт-43

Үүнээс: 2021 онд -39

2022 онд - 4

Түргэвчилсэн шинжилгээ:

Нийт хийсэн түргэвчилсэн шинжилгээ /2021-2022 он/- 54595

Үүнээс: 2022 онд-11438

Сүүлийн 7 хоногт хийсэн шинжилгээ-207

Үүнээс эерэг -14

ПСР шинжилгээ:

Нийт хийсэн ПСР шинжилгээ /2021-2022 он/-89594

Үүнээс 2022 онд-12082

Сүүлийн 7 хоногт хийсэн шинжилгээ-37

Үүнээс эерэг -10

Вакцинжуулалт:

1-р тунд 60893 хүн буюу 87.23 хувь /12-с дээш нас/
2-р тунд 57627 хүн буюу 82.80 хувь /12-с дээш нас/
3-р тунд 27334 хүн буюу 48.88 хувь /18-с дээш нас/
4-р тунд 2516 хүн буюу 5.01 хувь /18-с дээш нас/

Тав. Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд

Мал аж ахуй

Аймгийн 19 сумын 101 багийн 3.7 сая га бэлчээрт 8202 хот айлд 19.7 мянган малчин, мал бүхий өрхийн 6.1 сая орчим толгой малыг өвөлжүүлж, хаваржуулах бэлтгэл ажлыг хангалаа.

Малчин өрхүүд 400 гаран га талбайгаас 600 орчим тн ногоон тэжээлийг хураан авсан. 2022 онд нэмэгдэл тэжээлд 700.7 мянган толгой мал орж, байран маллагаанд 50.2 мянган толгой мал өвөлжинө.

Улсын тусгай хамгаалалттай бүс нутагт Хангай, Чулуут Булган, Цэнхэр, Тариат сумдын 310 өрхийн 194.8 мянган толгой мал өвөлжиж, хаваржина.

Бусад аймагт: Хашаат, Өгийнуур, Хотонт, Хангай сумдын 57 өрхийн 30.9 мянган толгой мал Булган, Төв, Дорнод, Хэнтий, Баянхонгор аймагт отроор;

Бусад аймгаас: Өвөрхангай 2 өрхийн 291 толгой, Завхан 6 өрхийн 3954 толгой, Увс аймаг 1 өрхийн 1005 толгой, Говь-Алтай аймгийн 1 өрхийн 170 толгой буюу нийт 7 суманд 10 өрхийн 5420 толгой отроор

Аймаг дотроо: Жаргалант, Хашаат сумдын 74 өрхийн 38.4 мянган толгой мал Өндөр-Улаан, Цэцэрлэг, Өлзийт, Өгийнуур, Хотонт сумдын нутагт тус тус отроор өвөлжиж, хаваржих төлөвтэй байна.

Малчдын түвшинд 80 мянган тн өвс, 1300 тн гар бэлтгэхээс 68.7 мянган тн өвс, 860 тн ногоон тэжээл, 535 тн үйлдвэрийн тэжээл, 1097 тн гар тэжээл, 7 тн дарш, ногооны хаягдал, 3755.5 тн давс, хужир шүүг бэлтгэн хадлан бэлтгэл 90,3 хувьтай байна.

Аймаг сумын аюулгүйн нөөцөд 1670 тн өвс, 620 тн гар тэжээл бэлтгэхээс 1279.5 тн өвс, 402.3 тн ногоон тэжээл, гар тэжээл бэлтгэн 70.8 хувьтай байна.

Өвөл, хаврын бэлчээрийн даац нутгийн 20 гаруй хувьд хүрэлцээтэй, 80 орчим хувьд нь хэтэрсэн. Зудын эрсдэлийн ерөнхий үнэлгээгээр Архангай аймаг дунд зэрэглэлтэй гарсан.

Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2022 оны "Шүлхий өвчнөөс сэргийлэх намрын нэгдсэн дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах тухай" А/191 дүгээр тушаал, аймгийн Засаг даргын 2022 оны "Дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах тухай" А/674 дүгээр захирамжийн хүрээнд 17,2 мянган өрхийн 933,8 мянган үхэр, 1,245 гахай нийт 935,1 мянган толгой мал, амьтан дархлаажуулалтад хамруулахаас 13,4 мянган өрхийн 908,9 мянган үхэр, 1824 гахай, нийт 910,7 мянган мал, амьтан хамруулж дархлаажуулалтын ажил 97,3 хувьтай хийгдэж дууссан.

Бог малын гоц халдварт мялзан өвчний дархлаажуулалтын ажлыг Жаргалант, Хайрхан, Цэцэрлэг сумдад зохион байгуулж, нийт 42 мянган толгой малыг хамруулллаа.

Газар тариалан

2022 онд газар тариалангийн үйлдвэрлэл аймгийн хэмжээнд улаанбуудай 10453 га-д тариалж 130%, арвай 70 га-д тариалж 70%, хошуу будаа 340 га-д тариалж 170%, тосны ургамал 1225 га-д, малын тэжээл 2440 га-д, хүнсний ногоо 126.3 га-д, төмс 263.2 га-д, жимс, жимсгэнэ 84.7 га-д тариалж, нийт 15003 га талбайд тариалалт хийсэн нь төлөвлөсөн хэмжээнээс 11 хувиар нэмэгдсэн.

Намрын ургац хураалтад комбайн, хадагч 18, будаа цэвэрлэгч 6, үр сортлогч 1, ачигч 7, төмс ухагч 20 зэрэг чиргүүл дүүжин машины бэлэн байдлыг ханган технологит хугацаанд зохион байгуулж, ажиллах хүчин оюутан 42, бусад 573, нийт 615 хүнийг түр ажлын байраар хангасан.

Үр тариа 9393 га талбайгаас 9987 тн, тэжээлд 1420 га талбай шилжиж 2840 тн өвс боож, 50 га мөндөрт цохиулж ургац алдсан. Төмс 263.2 га-аас 1631 тн, хүнсний

ногоо 125 га-аас 929 тн, 1.1 га талбайн хүнсний ногоо мөндөрт цохиулсан, тэжээлийн ургамал 2399.9 га-аас 4469.3 тн, 40.5 га талбайн тэжээл мөндөрт цохиулсан. Тосны ургамал 875 га-аас 408.5 тн, 350 га мөндөрт цохиулж ургац алдсан. Аймгийн хэмжээнд 15003 га талбайгаас 20265 тн ургац хураан авч, ургац хураалтын ажил 100 хувьтай дууссан.

Зургаа. Байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн салбарын бодлогын хүрээнд

Ногоон байгууламж, мод тарих

Архангай аймаг нь “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 2021-2030 оныг хүртэлх хугацаанд 20 сая мод тарьж ургуулах ажлын төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэн ажиллаж байна.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хавар, намрын тарилтаар 19 сумын хэмжээнд 497,016 ширхэг мод, бут сөөгийг үрээр болон тарьц суулгацаар тарьж усалгаа, арчилгааны ажлыг гүйцэтгээд байна. Төв суурин газрын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор сумдын төвийн хашаа, хамгаалалттай сад, цэцэрлэгт хүрээлэнг засаж сэлбэн сайжруулж мод тарих чиглэлийг сумдын Засаг дарга нарт өгч ажилласан. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх, уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, элсний нүүлтийг зогсоох, иргэдийн ажиллаж амьдарч буй орчныг ногоон байгууламжтай болгох зорилгоор нэг иргэн нэг мод уриалгыг өрнүүлж иргэд аж ахуйн нэгж, байгууллагыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж байна. Мөн ойн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсэгт заасны дагуу ойн мэргэжлийн байгууллагууд бэлтгэсэн модныхоо тоо хэмжээнээс хамааруулан ойжуулалтын ажлыг өөрсдийн хөрөнгөөр хийж гүйцэтгээд байна.

2022 онд “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд аймгийн хэмжээнд нийт 478.0 мянган ширхэг модыг тарихаар төлөвлөснөөс 497.0 мянган ширхэг модыг тарьж ажлын гүйцэтгэл 100 хувьтай байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Монгол Улсын их сургуультай хамтран бүс нутгийн онцлогт тохирсон модны зүйлийг сонгох, үр түүж бэлтгэх, тарьц суулгац ургуулах, мод тарьж ургуулах, арчлан хамгаалах технологийн талаар нэгдсэн мэдлэг өгөн иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад зааж сургах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллах “Сургагч багш”-ийг бэлтгэх сургалтад 19 сумын 57 иргэн хамрагдан ажиллаж байна.

Улсын төсвийн 198.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Мастер Эрчим” ХХК нь Эрдэнэбулган сумын 2-р багт ногоон байгууламж байгуулах ажлаар 1000 ширхэг шар хуайс, 56 ширхэг улиас тарьсан.

Булган, Цэнхэр сумын ойд арчилгаа, цэвэрлэгээ явуулах тусгай зөвшөөрөлтэй 13 ойн мэргэжлийн байгууллага хамтран Эрдэнэбулган сумын улсын чанартай авто зам дагуу 600 м^2 талбайг хашиж (6м*100м), 70 гаруй ширхэг шинэсний суулгац тарьж, услаж арчилж хамгаалсан.

Хог хаягдлын менежмент

Тэрхийн цагаан нуурын хойд, урд хэсэг Чулуутын хавцал, Хөх нуур, хойд Тамир голын эх, Суварга хайрхан Ширдэгийн гол, Ихтамир сумын Хойд тамирын гол, Өндөр-Улаан сумын Бэлхи багт орших Чулуутын гол, Тарвуу, Тамирын голын голдирол дагуух хог хаягдал болон нийтийн эзэмшлийн зам талбай, голын голдирол, улсын болон орон нутгийн чанартай зам дагуух хог хаягдал цэвэрлэх ажлыг 587 аж ахуй нэгж байгууллагын 16124 ажилтан албан хаагч, иргэд оролцож, 613 машин техник ашиглан 1832.8 га талбай, 254 км голын голдирол, 1096 км улсын болон орон нутгийн чанартай зам цэвэрлэн 2673 тн хог хаягдал, малын сэг сэм ачиж зайлуулж төвлөрсөн хогийн цэгт хаясан.

Чулуут сум ОНХС-ийн 120 сая төгрөгийн санхүүжилтээр сумын хогийн цэгийг 3-р зэрэглэлийн хог хаягдлын төвлөрсөн цэгийн стандартын шаардлагад нийцүүлэх ажлыг хийж, 25 га талбайг 5 га хүртэл багасгасан, Өндөр-Улаан ОНХС-ийн 70 сая төгрөгийн санхүүжилтээр хуучин хогийн цэгийг засварлан 4 га талбайг 2 га хүртэл багасгаж, шинээр цооног ухаж, торон хашаа, камер суурилуулсан.

Хангай сум ОНХС-ийн 15 сая төгрөгийн санхүүжилтээр хогийн цэгийн хэмжээг багасгах, хог хаягдлыг түрж дарах, булшлах, камержуулах ажлыг сумын иргэдийн бүлэгтэй гэрээ байгуулан гүйцэтгэсэн. Хотонт сум ОНХС-ийн 20 сая төгрөгийн санхүүжилтээр “Хог хаягдлын менежментийг сайжруулах” дэд хөтөлбөрийн хүрээнд сумын төвийн хогийн цэгийн хогийг дарж, булшлах, камержуулах ажлыг хийсэн. Мөн тус сумын Өндөрсант багийн 4,5 га, багийн төвийн 1,14 га талбай хог хаягдлыг ландфилийн аргаар дарж, булшлах ажлыг хийсэн.

“Монголын унаган байгалийн хүлцэл тогтворжилтийг хангах нь” төслийн 45 сая, сумын ОНХС-ийн 45 сая, нийт 90 сая төгрөгний санхүүжилтээр Хайрхан суманд “Хог хаягдлын менежмент, дахин боловсруулалтын санал санаачилгыг дэмжих нь төсөл” хэрэгжиж ажлын гүйцэтгэл 80 хувьтай байна. Өлзийт суманд ахуйн хог хаягдлыг ангилан ялгах цэг байгуулах, ангилан ялгасан хог хаягдлыг зах зээлийн эргэлтэд оруулах "Цэвэр сайхан" төслийг “Монголын унаган байгалийн хүлцэл тогтворжилтийг хангах нь” төслийн хүрээнд хэрэгжүүлж байна. Эрдэнэбулган сумын 5-р багт бүх төрлийн гялгар уут, тор, сав баглаа боодлын гаднах гялгар болон хуванцар савыг дахин боловсруулан хашаа, шонгийн бэлдэц хийх эцсийн бүтээгдэхүүн болгон гаргах үйлдвэр байгуулсан бөгөөд түүхий эдээ авч, тоног төхөөрөмжүүдээ суурилуулж, үйл ажиллагаа эхлэхэд бэлэн болоод байна.

Барилга байгууламж, дэд бүтэц, орон сууц,

2022 оны 11 дүгээр сарын байдлаар хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар 6 байршилд 202 айлын орон сууц байнгын ашиглалтад орж, 2022 онд нийт 12 байршилд 417 айлын орон сууц баригдаж байгаагаас 215 айлын орон сууц он дамжин баригдана.

АРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

------oOo------